

3

МАЛЧИН ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭЛТИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Л.Хурцбилиг

Товч агуулга:

Өвөр монголын бэлчээр хадлан багасч элсний нүүдэл нэмэгдсээр байна. Жил ирэх бүр бэлчээр нутаг доройтон, хүрэлцээ хангамж нь буурч, байгаль цаг уурын хүчин зүйлс хурдацтай өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ бүс нутагт хүн амын өсөлт хурдацтай явагдаж байгаа нь мал аж ахуйн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Өвөрмонголын засгийн газраас малчдын малын тоо толгойг хязгаарлах, тодорхой хугацаанд бэлчээр ашиглахыг хориглох, малыг байнгын тэжээлд оруулах, малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх зэрэг бодлогын чанартай арга хэмжээ авч байна. Гэвч дээрх арга хэмжээ нь малчдын сонирхолтой нийцэхгүй байгаагаас хэрэгжүүлэх явцад тодорхой бэрхшээлтэй тулгарч байна. Иймд дээрх хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Шулуун хөвөө цагаан хошууны жишээн дээр малчин өрхийн орлого ба үйлдвэрлэл эрхлэлтийн өнөөгийн байдлыг судлан малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлтийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлох юм.

Түлхүүр үг:

- Малчин өрх
- Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэлт
- Өвөрмонгол

**1. Өвөрмонголын малчин, тариачин өрхийн орлого
зарлагын харьцуулалт**

1970 оны эцсээр болсон өөрчлөлтийн эхний үед Өвөр Монголын малчид, тариаланчдын нийт орлогод хувийн аж ахуйн орлогын эзлэх хэмжээ нь тухайн үед малчид нэгдлийн мал малладаг байснаас шалтгаалан бага, амины малын тоо нь дунджаар 15 толгой байсан. Ийм учраас хувийн малын ашиг шимийг бага

хүртдэг байсан юм. Өвөр Монголын тухайн үеийн бүртгэлийн материалыг үндэслэвэл, 1978 онд малчин өрхийн нийт орлогын дотор өрхийн аж ахуйгаас олсон орлогын эзлэх харьцаа нь:

- малчин өрхөд 25.89%
- тариачин өрхөд 43.48%-ийг эзэлж

малчид, тариачдын орлогын ихэнхи хэсэг нь хамтын аж ахуйгаас орж ирдэг байжээ. Мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийн хариуцлагын дүрмийг хэрэгжүүлэхийн (*хамтын аж ахуйг задлаж хувийн хэвшилд шилжүүлэх төрийн бодлогыг дагалдан*) хамт малчид, тариачдын өрхийн аж ахуй нэмэгдсэнээр орлогын бүтцэд үндсэн өөрчлөлт гарсан юм.

Өвөр Монголын тариачин өрхийн нийт орлогын дотор өрхийн аж ахуй эрхлэлтээс олсон орлогын хувь хэмжээ нь 1995 онд 95.67% -д хүрч, түүнээс хойш буурч 2008 онд 80.32% болж, 13 жилд 15.35%- иар доошилсон байна. Мөн хугацаанд малчдын гэр бүлийн нийт орлогын дотор өрхийн аж ахуй эрхлэлтээс олсон орлогын эзлэх хэмжээ нь 1995 онд 98.6%-ийн хамгийн өндөр цэгт хүрсэн бөгөөд түүнээс хойш бууран 2008 онд 88.75% болж, 1995 оноос 9.8 % иар багассан байна.

Өвөр Монголын 2009 оны статистикийн мэдээг үндэслэвэл, 2008 онд тариачдын гэр бүлийн хүн бүрийн цэвэр орлогын дотор цалингийн орлого, шилжилтийн орлого буюу төрөөс эсвэл орон нутгийн байгууллагаас олгож байгаа тусламж, нөхөн олговор, урамшууллын орлого, янз бүрийн зардлын хөнгөлөлт болон эд хөрөнгийн орлогын (*хөрөнгө түрээслэсний орлого, хүүгийн орлого гэх мэт*) эзэлж байгаа харьцаа нь малчдын өрхийн орлогын эзэлж байгаа харьцаанаас илүү өндөр байж, дээрхи гурван зүйлийн нийлбэр нь цэвэр орлогын 32.61%-ийг эзэлж байна. Гэтэл малчин өрхөд зөвхөн 21.35%-ийг эзэлж, тариачин өрхийн орлогоос 11.26% доогуур байсаар байна.

2008 оны нийт зардалд хүн бүрт ногдох өрхийн үйлдвэрлэлдээ зарцуулсан зардлын эзлэх харьцаа нь малчин өрхөд 41%-ийг эзэлж, тариачин өрхөд 31% байж малчин өрх нь тариачин өрхөөс 10%-иар их байна.

Өрхийн хэрэглээний зардал нь малчин өрхөд 49%-ийг, тариачин өрхөд 46%-ийг эзэлж малчин өрх нь тариачин өрхөөс 3 % доогуур байна.

Өрхийн гишүүн бүрд ногдох дундаж зардлаас үзвэл, 2007 онд малчин өрх нь тариачин өрхөөс 7% хувь өндөр байж, хувийн хэрэглээний зардал нь 65% бага байна.

Зохиогч 2007-2008 оны хугацаанд Шулуун хөвөөт цагаан хошууны 20 малчин өрхөд судалгаа хийж үзсэн бөгөөд малчин өрхийн нийт орлого нь 43485.10 юань байж, үүнд хонины ашиг шимийн орлого 23355.25 юань мал аж ахуйн нийт орлогын 53%-ийг эзэлж, ямааны орлого 11630.55 юань буюу өрхийн нийт орлогын 27%-ийг эзэлж, үхрийн орлого 6352.75 юань нийт орлогын 15%-ийг эзэлж, бусад орлого (адуу зэрэг) 2146.55 юань байж, нийт орлогын 5%-ийг

эзэлж байна. Мал аж ахуйн нийт орлогоос үйлдвэрлэлийн зардал буюу өвс, тэжээл бордоо, мал эмнэлгийн зардал, нутаг бэлчээрийн ашиглалтын болон ажиллах хүчний зардал зэргийг хасвал, өрх бүр дунджаар мал аж ахуйн үйлдвэрлэлээс олсон цэвэр орлого нь 8182 юань болно. Үүнээс үзвэл малчин өрхийн орлогын гол эх үүсвэр нь хонь, ямааны аж ахуйгаас олж, олонх малчин өрхийн үхэр ба адуу маллаж байгаа зорилго нь голдуу өөрийн сүү сааль ба өрхийн хэрэгцээгээ хангахад оршиж байна.

2. Малчин өрхийн нутаг бэлчээрийг эзэмшиж, ашиглаж байгаа байдал

Судалгааны үр дүнгээс харахад 1950-иад оны дунд үед Шулуун хөвөөт цагаан хошууны газрын 1 гектар нутаг бэлчээрт 3.8 хонь маллах даацтай байв. Тухайн газар орны засаг захиргааны нэгжээс тогтоосон малын тоог хязгаарлах бодлогыг үндэслэвэл, одоогийн нутаг бэлчээрийн даацын хэмжээ нь 1 гектар бэлчээрт зөвхөн 0.9 хонь болж, хагас зууны хугацаанд нутаг бэлчээрийн даацын хэмжээ нь дөрөвний нэг хүртэл доройтсон байна. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн малын тоо толгой нь өрх бүр дунджаар 387 хонин толгой байж, энэ нь өрх бүр дунджаар бэлчээрийн даацаар хязгаарлах бодлогоос шалтгаалан 286 хонин толгойноос үл хэтрэх болно. Энэ нь малын төллөх хугацаа үндсэндээ дуусаж, малын тоог хязгаарлах тогтоолын дагуу жилийн эцэст малчид малаа цөөлж хязгаарласан тоо толгойн дотор тохируулах хэрэгтэй. Энэхүү байдлаас үзвэл, одоохондоо малчин өрхийн мал аж ахуйн үйлдвэрлэл хязгаарлагдаж байгаа гол шалтгаан нь бэлчээрийн талбай хүрэлцэхгүй ба нутаг бэлчээрийн мал бэлчээх даацын хэмжээ буурсанаас шалтгаалж байна. Малчид өрх гэрийн амьдрал ахуйгаа дээшлүүлэхийн тулд аль болохоор малаа өсгөн үржүүлж, малынхаа тоо толгойг нэмэгдүүлдэг. Гэвч малын тоог хязгаарлах төрийн бодлогоор жилийн эцэс болоход нэлээд олон толгой малаа хорогдуулах шаардлагатай болдог. Энэ үед малын зах зээлийн үнэ ямар байгаагаас үл хамааран малчид заавал малаа худалдан борлуулж төрөөс тогтоож өгсөн хэмжээнд хүртэл малын тоо толгойгоо хорогдуулдаг. Энэхүү байдал нь малчдын үйлдвэрлэл эрхлэлт, зах зээл дээрх өрсөлдөх чадварыг бууруулж, ихэнхи малчин өрхийн үйлдвэрлэл нэмэгдсэн ч орлого нь өсөхгүй байдлыг бий болгож байна.

3. Малчин өрхийн аж ахуй эрхлэлтийн одоогийн байдал

20 малчин өрхийн малын бүтцэд

- хонь 61%
- ямаа 33%
- үхэр 6%
- адуу 0.4%-ийг эзэлж байна.

Үүнд 5 өрх нь хонь, ямаа, үхэр болон адуутай бол, 13 өрх нь хонь, ямаа болон үхэр, 1 өрх нь хонь болон ямаа, 1 өрх нь хонь болон үхэртэй байна.

Гурван төрлөөс дээш малтай өрх нь 90%-ийг эзэлж байгаагаас үзвэл, малчин өрхийн үйлдвэрлэлийн төрөлжилт өндөр биш. Малчдын өөрсдийнх нь үзэж байгаагаар өнөөгийн нөхцөлд малчин өрхөд олон төрлийн малтай байх нь дараах давуу талуудтай:

(1) Олон төрлийн малтай байх нь нутаг бэлчээр болон тэжээлийн ашиглалтыг дээшлүүлэх давуу талтай.

(2) Малын төрөл олон байх хоорондоо дагалдах бүтээгдэхүүнээ харилцан ашиглах ба мал аж ахуйн үйлдвэрлэлд ашигтай нөхцлийг бий болгодог.

(3) Малчин өрхийн амьдралын хэрэгцээнд шаардлагатай олон төрлийн малын ашиг шим хүртэхэд ашигтай.

(4) Малжих үйлдвэрлэлээс олох орлогын төрлийг олон зүйл болгож, малын ашиг шимийн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс бий болох эрсдлийг бууруулахад ашигтай.

(5) Малын ашиг шимийг хүртэх цаг хугацаа нь мал болгон дээр адилгүй болохоор олон төрлийн мал малжих нь мөнгөний урсгалыг жигдрүүлж, малчин өрхийн үйлдвэрлэл, амьдрал ахуйд шаардлагатай мөнгөний хэрэгцээг цаг тухайд нь нөхөж өгдөг ашигтай.

Судалгаанаас үзэхэд малчин өрхийн 80% нь ямаа маллаж байгаа бөгөөд гол зорилго нь ямааны ноолуурыг зуны эхээр хамгийн түрүүнд борлуулдаг болохоор малчин өрхийн улирлын чанартай мөнгөний яаралтай хэрэгцээг шийдвэрлэж өгдөг.

(6) Бэлчээрт нэг доор нэг хүн хонь болон үхрийн сүргийг зэрэг хариулах бололцоотой болохоор хөдөлмөр хэмнэхэд ашигтай.

(7) Малын ашиг шимийн үйлдвэрлэлийн бүтцийг тохируулахад ашигтай байдаг.

Малчин өрх олон төрлийн малыг маллах нь дараах хэд хэдэн талын сул талтай:

(1) Нэг өрхөд олон төрлийн мал маллах нь үйлдвэрлэлийн өөрийн өртгийг бууруулахад ашиггүй.

(2) Хашаа хорооны зардлыг нэмэгдүүлдэг.

(3) Үйлдвэрлэлийн тоо хэмжээг өргөтгөхөд бэрхшээлтэй.

(4) Ажиллах хүчний ачааллыг нэмэгдүүлэх.

(5) Амрах ба суралцах цаг хүрэлцэхгүй зэрэг болно.

Малчин өрх нь нийтдээ хоёр төрлөөс дээш мал маллаж байгаа нь өнөөгийн малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлтийн нийтлэг дүр төрх юм. Нэг талаар энэхүү үйлдвэрлэлийн бүтэц нь уламжлалт нүүдэл мал аж ахуйн нэг талын үргэлжлэл байж, өөрийгөө хангах чадвартай үйлдвэрлэлийн хэрэгцээтэй нягт холбогдож, бэлчээрийн мал аж ахуй дахь малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлтийн онцлогоос үндэслэлтэй байна. Нөгөө талаар малчид малын ашиг шимийн хангалт хэрэгцээ, үнэ болон бизнесийн мэдээллийг цаг тухайд нь олоход хүндрэлтэй байж, олон

төрлийн малын ашиг шимийн үйлдвэрлэлийн эрсдлийг багасгах шууд арга хэмжээ авахад бэрхшээлтэй.

3.2 Малчин өрхийн хонины үүлдрийн бүтцийн одоогийн байдал

Малчин өрхийн малын төрлийн бүтцэд хонины эзлэх хувь нэлээд их байгаа болохоор, хонины үүлдрийн бүтцээр жишээлж малчин өрхийн үйлдвэрлэлийн бүтцэд гүнзгийрүүлэн шинжилгээ хийж үзвэл, өнөө үед малчин өрхийн хонины үүлдрийн бүтцэд ноос махны хос хэрэгцээт үүлдэр 62%-ийг эзэлж, нутгийн махны хэрэгцээт хонины үүлдэр 32%-ийг эзэлж, бэсрэг буюу эрлийз үүлдэр 6%-ийг эзэлж байна. Үүнээс хойш хонины үүлдрийн бүтэц болон хонины тоо толгойн хэмжээгээ хэрхэн тохируулах тухай малчдын бодлыг сонсоход 10 өрх нь цаашдаа нутгийн хонины үүлдэр болон эрлийз үүлдрийн эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх сонирхолтой байна. Шалтгаан нь нутгийн хонь болон эрлийз үүлдрийн хонины махны үйлдвэрлэлийн бүтээмж, үржилт бойжилтын норм нь өндөр бөгөөд маллагааны өөрийн өртөг нь бага, хатуу ширүүн байгалийн орчин нөхцөлд зохицох чадвараар сайн байдагт оршино. Ноос махны хос хэрэгцээт өвөр монголын нарийн ноост хониор гол болгох бодолтой 3 өрх байж, шалтгаан нь тус үүлдэр нь тухайн газар орны байгалийн нөхцөлд нэлээд сайн зохицож, мах болон ноосоор гол чиглэл болгох нь зах зээлийн үнийн өөрчлөлтөөс болох эрсдлийг багасгахад ашигтай гэж үзэж байна. Үүнээс гадна нарийн ноост хонины үүлдрээр гол болгох чиглэлтэй 2 өрх хониндоо гар (зохиомол) хээлтүүлэг хийж, тухайн үүлдэрийн хуц үржүүлэхээр гол чиглэлээ болгож байгаа өрх нэг байна. Цаашдаа махны хэрэгцээт шинэ үүлдрийг оруулах тухай малчдын санаа бодлыг сонсоход 4 өрх нь туршиж үзэх санаатай гэж хариулж, бусад өрх нь тийм их сонирхолгүй байв. Шалтгаан нь шинээр оруулж ирсэн үүлдрийг бодвол нутгийн хонины үүлдэр нь тухайн газрын байгалийн нөхцөлд зохицох чадвараар сайн бөгөөд үйлдвэрлэлийн өөрийн өртөг нь хямд байдаг. Тэгвэл бэлэн мөнгө дутмаг, туршлага хүрэлцэхгүйн дээр хонины махны зах зээлийн эрэлтийн хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй зэрэг асуудлууд оршиж байна.

Малчин өрхийн хонь ихээр өсгөх зорилго нь хонины мах болон ноос үйлдвэрлэх хоёрдмол зорилготой байхыг дээрх судалгаанаас ойлгож болно. Тус газар орон нь Өвөр Монголын нарийн ноост хонины үйлдвэрлэлийн суурин газар байж, 10 жилийн өмнө хонины үүлдрийн бүтцэд нутгийн хонины үүлдэр (монгол хонь) болон эрлийз үүлдэр тун цөөн байж, Өвөр Монголын нарийн ноост ноос, махны хос хэрэгцээт үүлдэр зонхилж байсан юм. Хонины махны зах зээлийн хэрэгцээний өсөлтийг дагалдан, малчдын хонины үүлдрийн бүтэц нь ноос махны хэрэгцээнээс мах ноосны хэрэгцээт үүлдрийг үндсэн чиглэлээ болгох хандлагатай болжээ. Гэвч судалгаанд хамрагдсан зөвхөн нэг л малчин өрх гадаад улсаас оруулсан махны хэрэгцээт хонины үүлдрийг туршиж байгаа нь харагдсан бөгөөд ерөнхийдөө эрлийз үүлдрийн хонины эзлэх хувь бага байгаа байдлаас үзвэл уламжлалт мал маллагааны арга голлох байр суурийг эзэлж байна.

3.3 Малчин өрхийн хонин сүргийн бүтцийн одоогийн байдал

Малчин өрхийн хонин сүргийн тоо хэмжээ нь дунджаар 190 толгой хоньтой, үүнд үржлийн насны эм хонь 87 толгой байж, хонин сүргийн 45,8%-ийг, зусаг (эм шүдлэн) 18 буюу 9%-ийг, хуц 18 буюу 1% орчмыг, цагаалсан (эр хонь) хонь 9 буюу 5%-ийг эзэлж, хурга 40%-ийг эзэлсэн хонин сүргийн бүтэцтэй байгааг судалгаагаар тогтоосон юм.

Үржлийн насны эм хонь хийгээд хуцын харьцаа нь 1:49 байгаагаас үзвэл, малчид голдуу хонин сүрэгтээ байгалийн хээлтүүлгийн аргыг хэрэглэж байна. Тухайн нутгийн малчид ерөөсөө хурганы мах иддэггүй бөгөөд цагаалсан (зассан хонь) хонийг голдуу өөрийн хэрэгцээндээ зарцуулдаг. Ерөнхийд нь авч үзвэл, хонин сүргийн бүтцийн дотор төллөх эм хонь болон хурганы харьцаа нь нэлээд өндөр бөгөөд малчдын хонь өсгөн үржүүлж байгаа гол зорилго нь хурганы мах үйлдвэрлэх хандлагатай болж байна.

3.4 Малчин өрхийн малын ашиг шим арилжааны одоогийн байдал

Одоохондоо малчид бүтээгдэхүүнээ 3 арга замаар борлуулж байна.

(1) Явуулын арилжаачинд малаа шууд борлуулах арга зам. Судалгаанд энэхүү арга замаар малаа худалдаж борлуулдаг 12 өрх, үүнээс 9 өрх нь нэлээд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн бөгөөд шалтгаан нь явуулын наймаачин шууд газар дээрээс нь ирж худалдан авдаг болохоор 2 тал үнээ тохиролцон наймаалцаж, мөн илүү зардал малчнаас гардаггүй давуу талтай юм. Гэвч 3 өрх нь энэхүү солилцооны үйл ажиллагаанд тийм их сэтгэл ханамжтай биш байлаа. Учир нь явуулын арилжаачинтай үнэ хаялцах үес малчид ерөөсөө ашиггүй байр сууринд байж, шудрага бус арилжаа болдог. Түүнчлэн заримдаа хуурамч мөнгө ашиглах, хонины жинг бууруулах үзэгдэл гардаг.

(2) Мал борлуулдаг тусгай аж ахуйн нэгжээр дамжуулж борлуулах. Ийм аргаар малаа 6 өрх борлуулсан. Үүнээс 2 өрх нь нэлээд сэтгэл ханамжтай байлаа. Шалтгаан нь үнэ ханш нь тохиромжтой, амар хялбар гэж үзэж байв. Нөгөө 4 өрх нь сэтгэл ханамжгүй байсан. Шалтгаан нь тухайн аж ахуйн нэгж нь танил тал харж үйлчилдэг, малын амьдын жин малчны төсөөлж байснаас зөрүүтэй бага гарах, малыг борлуулахын тулд удаан хугацаагаар хүлээх зэрэг шударга бусаар ханддаг сөрөг талтай.

(3) Малаа амьдаар нь тээвэрлэж өөр газарт борлуулах арга. Энэ аргаар малаа борлуулсан өрх 2 байна. Нэлээд ханамжтай үнээр борлуулж чадсан боловч, амьд малыг хол тээвэрлэх нь эрсдэлтэй бөгөөд багагүй бэрхшээлтэй.

1980-иад оны дунд үеэс Хятад улс малын арилжааг бүрмөсөн чөлөөтэй болгосноос хойш тухайн орон нутагт малыг худалдан авах, боловсруулах, борлуулах аж ахуйн нэгжүүд олноор бий болж малын худалдаа арилжаанд нэлээн өөрчлөлт гарсан юм. Гэвч зарим аж ахуйн нэгж болон малчдын хооронд харилцан итгэлцэх уур амьсгал хараахан бүрэлдээгүй байсаар байна. Иймээс энэ

чиглэлийн бизнесийн үйл ажиллагааны хууль, дүрэм журмыг улам төгөлдөржүүлэх шаардлага гарч байна.

3.5 Малчин өрхийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрүүл ахуйн өнөөгийн байдал.

Малчин өрхийн үйлдвэрлэлийн эрүүл ахуйн талаар орон нутгийн захиргааны байгууллагаас мал сүрэгт жилд 2-4 удаагийн малын өвчнөөс сэргийлэх эм тарилга хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна. Малчин өрхийн үржлийн мал худалдан авч хэрэглэж байгаа байдлыг судлаж, хуцаар жишээлбэл: үржлийн мал худалдан авахдаа малын удам угсааны тэмдэглэлийг судалж худалдан авсан 9 өрх, өмнө мэддэг байсан учраас шууд худалдан авсан өрх 6, гаднах төлөв байдлыг нь үзэж худалдан авсан өрх 5 байлаа. Хуцыг хэрэглэж байх цаг хугацааны талаар 2 жил хэрэглэн сольж байх өрх 17, 2-3 жил хэрэглээд сольдог өрх 2, 3 жил хэрэглээд сольдог өрх 1 байлаа.

Одоо малчин өрхийн үйлдвэрлэлийн өөрийн өртөгт өвс бордооны зардал нь бараг 60%-ийг эзэлж байна. Энгийн жилд малчин өрх зохих хэмжээний хуурай өвс хадаж хураах ба даршлах, тэжээл бордоо үйлдвэрлэхээс гадна, өрх бүр дунджаар 11834 юаны тэжээл бордоо худалдан авдаг. Голдуу эрдэнэ шиш, амуу будаа боловсруулахад бий болсон дайвар бүтээгдэхүүн жишээлбэл: маасан, базмаг зэрэг тэжээл бордооны эх материалыг худалдан авч хольж хэрэглэж байна. Ойрын жилүүдээс зах зээл дээрээс тэжээл бордоо шууд худалдаж авч байгаа боловч, цөөн бус малчдын санаа бодлоос үзвэл, үнэ нь хэтэрхий өндөр, чанар муу зэрэг олон асуудал оршиж байна.

Мал сүргийн өвчин хижгээс сэргийлэх талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагаас хяналтаа чангатгаж мал аж ахуйн үйлдвэрлэлийн эрүүл ахуйг хянаж байна. Гэвч үржлийн малыг хэрэглэх талаар цөөн тооны өрхийн мал сүрэгт төрлийн хээлтүүлгийн эмзэг асуудал оршиж байна. Иймээс нэг талаар үржлийн малын удмын бичиг байгуулах ба хяналтаа чангатгаж, нөгөө талаар үржлийн малыг хэрэглэх тухай мэдлэг мэргэжлийг дэлгэрүүлэх ажлыг бас хийх шаардлагатай байна. Таваарын тэжээл бордооны чанар дахь хяналтыг чангатгахын хамт, үнийг тогтвортой байлгах юм бол одоогийн малжих орны мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хандлага бүрэлдэн тогтох юм.

3.6 Малчин өрхийн үйлдвэрлэлийн өөрийн өртгөө бууруулах талаар авч байгаа гол арга хэмжээний байдал

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өөрийн өртгийг бууруулах талаар ямар арга хэмжээ авбал зохих вэ? (олон сонголтот асуулт) гэсэн асуултанд 15 өрх нь нутгийн хонины үүлдэр болон эрлийз үүлдэрийн харьцааг нэмэгдүүлж үйлдвэрлэлийн өөрийн өртгийг бууруулах, 16 өрх нь одоогийн үйлдвэрлэлийн хэмжээгээ хэвээр байлгаж, дахин өргөтгөж хөрөнгө оруулахгүйгээр үйлдвэрлэлийн өөрийн өртгийг бууруулах, 5 өрх нь өвс бордоог тохиромжтой ашиглаж, үйлдвэрлэлийн өөрийн өртгийг бууруулах, 10 өрх нь хоорондоо хоршиж мал сүргээ нэгтгэж, ажиллах хүчний зардлаа хэмнэх замаар

үйлдвэрлэлийн өөрийн өртгийг бууруулах мэт олон зүйлийн арга зам хайж байна.

4. Малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлтэд тулгарч байгаа гол асуудал

Уламжлалт нүүдлийн малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлт нь улирал хуваан ус бэлчээр сонгон сольж, байгалийн хүчийг зүй зохистой ашиглах нүүдэл мал малллагааны иж бүрэн мэргэжлийг бүтээсэн билээ. Энэхүү үйлдвэрлэлийн арга бодлого нь амьд бодисын олон зүйлт чанарын шаардлагад зохицуулж, амьтан хийгээд амьтны хооронд, амьтан хийгээд байгалийн хооронд, хүн төрөлхтөн хийгээд амьтан, хүн төрөлхтөн хийгээд байгалийн хоорондоо харилцан түшиглэлцэх харьцааг хүндэтгэсэн байна. Иймээс ерөөсөө эх байгальтай эе зохицолт харьцаагаа үргэлжлүүлж чадсан юм. Цаг үеийн улирлын өөрчлөлт ба нийгэм аж ахуйн орчны өөрчлөлтөөс болж, Өвөр Монголын нүүдэлчин малчдын үйлдвэрлэл амьдралын арга хэлбэрт ч маш их өөрчлөлт гарч байна. Одоохондоо малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлт нь макро болон микро орчны нөлөөн доор оршиж байна. Үүнд бодитой оршиж байгаа асуудал гэвэл:

(1) Тариачин өрхтэй харьцуулбал, малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлтэд өрхийн үйлдвэрлэлээс орж ирэх орлого нь их хувийг эзэлж, малчдын гэр бүлийн гишүүн бүрийн дундаж цэвэр орлого дахь цалингийн чанартай орлого, шилжилтийн чанартай орлого болон эд хөрөнгийн чанартай орлогын эзлэх харьцаа нь доогуур байна. Энэхүү байдал нь малчин өрхийн гэр бүлийн аж ахуй нь тариачин өрхөөс гэр бүлийн аж ахуйгаас илүү хүнд нөхцөлд үйл ажиллагаа явуулж байгаа ч тэдний орлогын түвшин доогуур байна. Энэхүү нөхцөлд амьдралын түвшнээ дээшлүүлэхэд зөвхөн мал аж ахуй л нэмэр болж байна. Гэтэл малчдын хүн бүрт ногдох нутаг бэлчээрийн талбай бага дээр, ойрын жилүүдээс нутаг бэлчээр талхлагдан доройтож, ялангуяа малын тоо толгойг хязгаарлах төрийн бодлого нь малчдын орлогын түвшинг хязгаарлаж байна.

(2) Малчдын үйлдвэрлэлийн өөрийн өртгийн өсөлт болон малын гаралтай бүтээгдэхүүгийн зах зээлийн үнэ ханш тогтворгүй байгаагаас болж малчдын орлогын өсөлт бий болоход сөргөөр нөлөөлж байна.

(3) Бэлэн мөнгө хүрэлцэхгүйгээс болж малчид үйлдвэрлэлийн бүтцээ сайжруулж чадахгүй байна.

(4) Малчид малын ашиг шимээ борлуулахад голдуу явуулын наймаачдыг түшиглэж, нэг айл нэг өрхийн тархай бутархай аж ахуй эрхлэлт нь зах зээлийн борлуулалт, зохион байгуулалтын хувьд учир дутагдалтай байна. Нөгөө талаар бизнесийн үйл ажиллагаанд малчид ашиггүй байр сууринаас оролцож байна.

Ерөхийдөө малчин өрхийн үйлдвэрлэлийн хэмжээ бага, зохион байгуулалтын түвшин оновчгүй, өөрсдөө малынхаа ашиг шимийг боловсруулах чадвар хүрэлцэхгүй, дахин үйлдвэрлэлд оруулах бэл бэнчин бага, үйлдвэржилтийн түвшин доор зэрэг асуудлууд оршиж байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ нь хэтэрхий бага байгаа нь дахин үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг багасган төвлөрүүлж аж ахуй эрхлэхэд хүндрэл учруулж байна.

Түүнчлэн зах зээлд шинээр бүтээгдэхүүн гаргах ба зах зээлийн өөрчлөлттэй дасан зохицох чадварыг доройтуулж байна.

Малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлт нь зах зээлийн эрэлт хэрэгцээг даган олон чиглэлээр хөгжих шаардлагатай бөгөөд мал аж ахуйн үйлдвэрлэлийн төрөл бүрийн чиг хандлагыг бусад хүчин зүйлтэй уялдуулах хэрэгтэй. Тал нутгийн экологийг хамгаалах ба сайжруулахын хамт, малчин өрхийн үйлдвэрлэл эрхлэлтийн бүтцийн дан цулгүй байдлыг хэрхэн өөрчилж, малчин өрхөд мал маллагаа, малын ашиг шим боловсруулах ба борлуулах зэрэг олон төрлийн үйлдвэрлэл эрхлэлтийн бүтцийг бий болгон, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар малчдын амьдралын түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна. Нөгөө талаар хөдөө орон нутгийн иргэдийн нийгэм ахуйн бодит байдлыг сайтар судлах шаардлага гарч байна.

Зүүлт: [1] Шулуун хөвөөт цагаан хошууны тойм байдал

Шулуун хөвөөт цагаан хошуу нь Өвөр Монголын Шилийн гол аймгийн баруун өмнө хэсэгт байршилж, газар зүйн байршил нь зүүн уртрагийн 114°05' - 115°37', умард өргөргийн 42°05' – 43°02'-д оршдог. Уур амьсгалын нөхцөл нь дунд дулаан бүсийн хагас гандуу эх хуурайд харьяалагдаж, жилийн дундаж дулааны хэмжээ нь 1 – 9 градус, дундаж хур тунадас нь 360 миллиметр, хяруу унахгүй хугацаа нь 112 өдөр болно.

Тус хошууны бүх газар нутгийн талбай 6215 тэгш дөрвөлжин километр (**кв.км**) байж, үүнд тал нутгийн талбай 92.8%-ийг эзэлж, тариан талбай 4.29%-ийг эзэлж, ой шугуй 1.72%-ийг эзэлж байна. Хошуу засгийн ордны бүртгэлийг үндэслэвэл, 2008 онд бүх хошуунд 25052 өрх, 72729 хүн амтай. Үүнд хотын харьяалалтай өрх 24.2%-ийг эзэлж, хөдөөгийн харьяалалтай өрх 75.8%-ийг эзэлж, бүх хошууны хүн амын нягтрал нь тэгш дөрвөлжин километр (**кв.км**) бүрд 11.7 хүн болно.

2008 онд бүх хошууны малын тоо нь 439625 толгой байж, үүнд бод мал 13%-ийг эзэлж, бог мал 87%-ийг эзэлж, бог малын дотор хонь 68.4%-ийг эзэлж байна. Тухайн жилийн малчин тариачин хүн бүрийн дундаж цэвэр орлого нь 3852 юань байж, үүнд тариачны хүн бүрийн дундаж цэвэр орлого нь 3749 юань, малчдын хүн бүрийн дундаж цэвэр орлого нь 4065 юань байж, хотын иргэдийн хүн бүрт ноогдох дундаж орлого нь 12037 юань болно.

2008 оны бүх хошууны үйлдвэрлэлийн нийт бүтэгдэхүүгийн өртөг нь 151442 0000 юань болж байна. Үүнд нэгдүгээр аж үйлс нь 19.25%, хоёрдугаар аж үйлс нь 50.00%, гуравдугаар аж үйлс нь 30.78%-ийг тус тус эзэлж буй. Шулуун хөвөөт цагаан хошуу бол Шилийн голын тал нутгийн чухал бүрэлдэхүүн хэсэг байж, ус бэлчээр үржил шимээрээ түүхэнд тэмдэглэгдэж ирсэн нутаг юм. Уур амьсгалын хувиралт болон хүмүүсийн үйл ажиллагааны нөлөөгөөр тус хошууны тал

нутгийн **экологи өдрөөс өдөрт доройтож** байна. Өнөөгийн байдлаар бүх хошууны талхлагдсан бэлчээрийн талбай нь бүх нутаг дэвсгэрийн 80%-ийг эзэлж, жил бүр бараг 13 мянган гектарын хурдцаар ихэсч буй. Өнгөрсөн хагас зууны турш нутаг бэлчээрийн өвсний ургацын хэмжээ нь гектар бүр 2250 килограмм байснаас одоо нэгэнт гектар бүр 570 килограмм хүртэл доошилжээ. Олонх малчин өрх жил бүр их хэмжээний өвс бордоо худалдан авч, мал аж ахуйн үйлдвэрлэлийн өөрийн өртөг нь жилээс жил нэмэгдсэн ч орлого дээшлэхгүй байна. Илүүдэл ажиллах хүчийг хэрхэн шилжүүлэх, нутаг бэлчээрийн **экологи, хүрээлэн буй орчныг** яаж хамгаалах, малчдын амьдралын түвшинг хэрхэн дээшлүүлэх зэрэг нь Шулуун хөвөөт цагаан хошууны эдийн засаг, нийгэмд тулгарч байгаа судлах шаардлагатай асуудал болж байна.